

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/068/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Төгс нотолгоо аудит ХХК-ийн Ахлах аудитор: Б.Дагвасүрэн Утас: 99889665 Цахим хаяг: tugsnotolgooaudit@gmail.com Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhand@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 03. 04

№

125

танай _____ -ны № _____ -т

Г ХӨХМОРЬТ СУМЫН ЕРӨНХИЙ Г
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН Г
ЗАХИРАЛ Г.ГЭРЭЛЦЭЦЭГ Г
ТАНАА Г

Г **Хязгаарлалттай дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Тайлант онд тус сургууль нь 2023, 2024 онуудын түлш халаалтын төлбөрт 96,339.5 мянган төгрөгийг гэрээ, гэрээ дүгнэсэн актгүй, үндэслэлгүйгээр илүү шилжүүлж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, хяналтгүй зарцуулсан,
- Тайлант хугацаанд дулааны эрчим хүчээр хангах, хэрэглэх гэрээний дүнгээс 24,938.1 мянган төгрөгийн илүү шилжүүлсэн,
- Сурагчдын улирлын амралтын хугацаанд 1, 8 дугаар сард багш нарт 1,464.4 мянган төгрөгийн анги даасны нэмэгдэл хөлс олгосон,
- Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад цалингийн зардлын төсвөөс 6,339.0 мянган төгрөгийг зарцуулсан зэрэг зөрчил илэрсэн.

822511000378

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, 27 дугаар зүйлийн 27.1.7, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4.3, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, 20.2.6 дахь заалтуудыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус байгууллагын улсын төсвийн санхүүжилт өмнөх өнөөс 432,631.5 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилт 293,792.8 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд хандиваар 58,240.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга, эд хогшлыг хүлээн авч, 5,136.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг шилжүүлсэн байна.

Тус байгууллага нь 2023 онд нэгдсэн халаалтын системд холбогдсон бөгөөд түлш халаалтын авлага, ер төлбөрийг нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, зааврын дагуу бүртгээгүй, дотоод хяналт үр нөлөөгүй зэрэг нь төсвийг үр ашиггүй зарцуулах, ер төлбөр үүсэх эрдсэлтэй байна.

Бусад асуудал

Тайлант онд 1 хөтөлбөр, 14 зорилт, 52 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 50 арга хэмжээг бүрэн, 2 арга хэмжээг дутуу хэрэгжүүлж, нийт дүнгээр 93.5 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд аймгийн Боловсролын газраас 88.9 хувиар "Хангалттай" гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж төлилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



[Handwritten signature] ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>118,967,505.71</u>	<u>125,203,139.81</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	25,322,739.63	41,229,279.18
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	25,322,739.63	41,229,279.18
3121	Төгрөг	25,322,739.63	41,229,279.18
31211	Төрийн сангийн харилцах	25,322,739.63	41,229,279.18
33	АВЛАГА	1,695,641.13	3,000,099.02
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,695,641.13	99.02
335	Бусад авлага	-	3,000,000.00
33510	Байгууллагаас авах авлага	-	3,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	91,949,124.95	80,973,761.61
351	Түүхий эд материал	3,275,000.00	3,275,000.00
35110	Тусгай зориулалттай материал	3,275,000.00	3,275,000.00
354	Хангамжийн материал	88,674,124.95	77,698,761.61
35420	Аж ахуйн материал	59,038,171.90	50,305,340.90
35460	Хүнсний материал	5,564,900.00	3,975,600.00
35470	Бусад хангамжийн материал	22,545,553.05	23,417,820.71
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,730,446,219.79</u>	<u>5,530,075,411.56</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,730,446,219.79	5,530,075,411.56
392	Биет хөрөнгө	5,700,446,219.79	5,494,075,411.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,580,794,362.80	5,587,171,362.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	(508,227,106.77)	(626,198,729.16)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	310,511,049.06	346,782,230.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	(144,013,836.26)	(197,917,245.88)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	322,686,223.32	321,542,139.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	(152,148,732.39)	(203,391,992.37)
39214	Бусад үндсэн хөрөнгө	358,936,643.00	364,536,643.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(68,092,382.97)	(98,448,997.63)
393	Биет бус хөрөнгө	30,000,000.00	36,000,000.00
39301	Програм хангамж	790,000.00	790,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(790,000.00)	(790,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	30,000,000.00	36,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,849,413,725.50</u>	<u>5,655,278,551.37</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>92,031,051.46</u>	<u>60,847,138.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	92,031,051.46	60,847,138.00
413	Өглөг	92,031,051.46	60,847,138.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	62,265,000.00	51,981,468.00
4136	Бусад өглөг	20,642,950.00	8,865,670.00
41361	Байгууллагад төлөх өглөг	20,642,950.00	8,865,670.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,757,382,674.04</u>	<u>5,594,431,413.37</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,757,382,674.04	5,594,431,413.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	729,023,210.08	729,023,210.08
51101	Өмч: - төрийн	729,023,210.08	729,023,210.08
512	Хуримтлагдсан үр дүн	4,920,486,617.47	4,757,535,356.80
51210	Өмнөх үеийн үр дүн	4,069,732,052.90	4,920,486,617.47
51220	Тайлант үеийн үр дүн	850,754,564.57	(162,951,260.67)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	107,872,846.49	107,872,846.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,849,413,725.50</u>	<u>5,655,278,551.37</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,358,838,837.46	3,010,090,791.04
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,149,419,437.46	74,247,091.04
120	Нийтлэг татварын бус орлого	1,149,419,437.46	74,247,091.04
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,873,600.00	6,001,778.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,663,600.00	1,826,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	210,000.00	4,174,978.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,098,778,137.00	58,240,181.82
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	48,767,700.46	10,005,131.22
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,209,419,400.00	2,935,843,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,834,357,000.00	2,266,988,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,834,357,000.00	2,266,988,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	375,062,400.00	668,855,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	375,062,400.00	668,855,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,486,430,270.13	3,172,395,551.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,486,430,270.13	3,172,395,551.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,435,273,328.43	3,090,175,138.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,527,550,401.46	1,847,493,263.85
210101	Үндсэн цалин	766,726,510.46	1,020,934,404.22
210102	Нэмэгдэл	668,549,941.00	728,792,690.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	6,339,000.00
210104	Урамшуулал	92,273,950.00	91,427,168.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	189,803,500.00	228,023,776.29
210201	Тэтгэврийн даатгал	129,066,300.00	153,312,976.29
210202	Тэтгэмжийн даатгал	15,184,300.00	18,699,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,592,200.00	9,369,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,592,200.00	9,443,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30,368,500.00	37,198,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	377,955,016.90	638,284,404.37
210301	Гэрэл, цахилгаан	10,264,804.35	13,397,125.92
210302	Түлш, халаалт	367,194,212.55	623,887,278.45
210303	Цэвэр, бохир ус	496,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,300,428.00	16,477,794.56
210408	Бараа материал акталсны зардал	15,300,428.00	16,477,794.56
2105	Нормативт зардал	36,056,150.00	46,900,770.00
210502	Хоол, хүнс	36,056,150.00	46,900,770.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,849,413.18	24,457,088.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,892,500.00	2,469,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,956,913.18	21,988,088.96
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	252,440,918.89	288,538,040.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,675,560.00	23,754,150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,800,000.00	6,172,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	215,965,358.89	258,610,990.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,156,941.70	82,220,413.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,057,368.60	61,913,950.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,544,700.00	61,913,950.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	19,200.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	19,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	99,573.10	20,287,263.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	99,573.10	20,287,263.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	872,408,567.33	(162,304,760.67)

Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	21,654,002.76	646,500.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	646,500.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(21,654,002.76)	(646,500.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	850,754,564.57	(162,951,260.67)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,211,293,000.00	2,941,845,478.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,873,600.00	6,001,778.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,873,600.00	6,001,778.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,873,600.00	6,001,778.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,663,600.00	1,826,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	210,000.00	4,174,978.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,209,419,400.00	2,935,843,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,834,357,000.00	2,266,988,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,834,357,000.00	2,266,988,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	375,062,400.00	668,855,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	375,062,400.00	668,855,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,227,972,709.78	2,925,938,938.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,227,972,709.78	2,925,938,938.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,167,700,268.08	2,841,532,974.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,518,427,300.00	1,854,920,823.20
210101	Үндсэн цалин	757,603,409.00	1,036,096,822.11
210102	Нэмэгдэл	668,549,941.00	721,057,733.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	6,339,000.00
210104	Урамшуулал	92,273,950.00	91,427,267.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	189,803,500.00	228,023,776.29
210201	Тэтгэврийн даатгал	129,066,300.00	153,312,976.29
210202	Тэтгэмжийн даатгал	15,184,300.00	18,699,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,592,200.00	9,369,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,592,200.00	9,443,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30,368,500.00	37,198,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	356,645,326.90	648,567,936.37
210301	Гэрэл, цахилгаан	9,999,804.35	13,662,125.92
210302	Түлш, халаалт	346,149,522.55	633,905,810.45
210303	Цэвэр, бохир ус	496,000.00	1,000,000.00
2105	Нормативт зардал	24,181,600.00	35,065,900.00
210502	Хоол, хүнс	24,181,600.00	35,065,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,588,581.18	24,457,088.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,892,500.00	2,469,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,696,081.18	21,988,088.96
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,736,460.00	50,497,450.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,285,860.00	44,104,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,450,600.00	6,393,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,272,441.70	84,405,963.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,172,868.60	64,099,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	44,660,200.00	64,099,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	19,200.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	19,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	99,573.10	20,287,263.63

Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	99,573.10	20,287,263.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(16,679,709.78)	15,906,539.55
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(41,497,209.78)	15,906,539.55
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	66,819,949.41	25,322,739.63
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	25,322,739.63	41,229,279.18

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын сруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь эрэлцээний нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	729,023,210.08	107,872,846.49	4,069,732,052.90	4,906,628,109.47
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	729,023,210.08	107,872,846.49	4,069,732,052.90	4,906,628,109.47
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	850,754,564.57	850,754,564.57
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	729,023,210.08	107,872,846.49	4,920,486,617.47	5,757,382,674.04
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	729,023,210.08	107,872,846.49	4,920,486,617.47	5,757,382,674.04
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	729,023,210.08	107,872,846.49	4,920,486,617.47	5,757,382,674.04
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(162,951,260.67)	(162,951,260.67)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	729,023,210.08	107,872,846.49	4,757,535,356.80	5,594,431,413.37

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

	ҮЗҮҮЛЭЛТ	БАТАЛСАН	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,988,710,700.00	2,905,651,674.82	83,059,025.18	97.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,988,710,700.00	2,905,651,674.82	83,059,025.18	97.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,919,511,200.00	2,841,552,174.82	77,959,025.18	97.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,895,279,000.00	1,854,920,823.20	40,358,176.80	97.9
210101	Үндсэн цалин	1,199,435,100.00	1,036,096,822.11	163,338,277.89	86.4
210102	Нэмэгдэл	641,608,300.00	721,057,733.36	(79,449,433.36)	112.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	6,339,000.00	(6,339,000.00)	#DIV/0!

**Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210104	Урамшуулал	54,235,600.00	91,427,267.73	(37,191,667.73)	168.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	237,439,500.00	228,023,776.29	9,415,723.71	96.0
210201	Тэтгэврийн даатгал	161,458,900.00	153,312,976.29	8,145,923.71	95.0
210202	Тэтгэмжийн даатгал	18,995,200.00	18,699,300.00	295,900.00	98.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,497,500.00	9,369,500.00	128,000.00	98.7
210204	Ажилгүйдлийн даатгал	9,497,500.00	9,443,500.00	54,000.00	99.4
210205	Эрүүл мэндийн даатгал	37,990,400.00	37,198,500.00	791,900.00	97.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	668,855,200.00	648,567,936.37	20,287,263.63	97.0
210301	Гэрэл, цахилгаан	15,000,000.00	13,662,125.92	1,337,874.08	91.1
210302	Түлш, халаалт	652,855,200.00	633,905,810.45	18,949,389.55	97.1
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
2105	Нормативт зардал	40,065,900.00	35,065,900.00	5,000,000.00	87.5
210502	Хоол, хүнс	40,065,900.00	35,065,900.00	5,000,000.00	87.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,951,300.00	24,457,088.96	1,494,211.04	94.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,701,600.00	2,469,000.00	232,600.00	91.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	23,249,700.00	21,988,088.96	1,261,611.04	94.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,920,300.00	50,516,650.00	1,403,650.00	97.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,519,800.00	44,123,250.00	1,396,550.00	96.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,400,500.00	6,393,400.00	7,100.00	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,199,500.00	64,099,500.00	5,100,000.00	92.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,199,500.00	64,099,500.00	5,100,000.00	92.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	69,199,500.00	64,099,500.00	5,100,000.00	92.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,988,710,700.00	2,921,558,214.37	67,152,485.63	97.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,287,837,900.00	2,266,988,500.00	20,849,400.00	99.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,287,837,900.00	2,266,988,500.00	20,849,400.00	99.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	668,855,200.00	648,567,936.37	20,287,263.63	97.0
132001	Орон нутгийн төсвөөс	668,855,200.00	648,567,936.37	20,287,263.63	97.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	32,017,600.00	6,001,778.00	26,015,822.00	18.7
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлого	2,701,600.00	1,826,800.00	874,800.00	67.6
120004 2	Туслах үйл ажиллагааны орлого	4,173,800.00	4,174,978.00	(1,178.00)	100.0
120004 3	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	25,142,200.00	-	25,142,200.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	25,322,739.63		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	41,229,279.18		

3.1 Аудитын залруулга

Аудитаар залруулга хийгээгүй болно.

Залруулагдаагүй нийт 122,742.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 122,742.0 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс 24,938.1 мянган төгрөгийн төлбөрийн акт, 96,339.5 мянган төгрөгийн албан шаардлага, 1,464.4 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлээ.

3.2 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд дулааны эрчим хүчээр хангах, хэрэглэх гэрээний дүнгээс 24,938.1 мянган төгрөгийн илүү шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

3.3 Албан шаардлага

Тус сургууль нь 2023, 2024 онуудад түлш халаалтын төлбөрт 96,339.5 мянган төгрөгийг гэрээ, гэрээ дүгнэсэн актгүй, үндэслэлгүйгээр илүү шилжүүлж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй хяналтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14 дүгээр зүйлийн 14.4.3-т "бүх өр төлбөр", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах", 20.2.6-т "бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын Засаг даргад ажлын хэсэг томилон дотоод хяналт хэрэгжүүлэх албан шаардлагыг хүргүүлсэн.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Цалин, хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сурагчдын улирлын амралтын хугацаанд 1, 8 сард багш нарт 1,464.4 мянган төгрөгийн анги даасны нэмэгдэл хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно" гэж заасныг зөрчсөн, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Багш нарт анги даасны нэмэгдлийг олгохдоо хууль эрх зүйн хүрээнд олгож байх

Илрүүлэлт: Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн өдрийн 5.0 мянган төгрөгөөр тооцож цалингийн зардлаас 6,339.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 27 дугаар зүйлийн 27.1.7-т "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах"-тай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид унаа хоолны хөнгөлөлтийг төсвийн төсөлд тусган, баталсан зардлын хүрээнд зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:													
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн							
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
1	Сурагчдын улирлын амралтын хугацаанд 1, 8 сард багш нарт 1,464.4 мянган төгрөгийн анги даасны нэмэгдэл хөлс олгосон	3	4	5	6	7	8	9	10	11	12						
	Тайлант хугацаанд дулааны эрчим хүчээр хангах, хэрэглэх гэрээний дүнгээс 24,938.1 мянган төгрөгийн илүү шилжүүлсэн.	1	24,938.1	1	24,938.1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын ерөнхий боловсролын сургууль	Тус сургууль нь 2023, 2024 онуудад тулш халаалтын төлбөрт 96,339.5 мянган төгрөгийг гэрээ, гэрээ дүгнэсэн актгүй, үндэслэлгүйгээр илүү шилжүүлж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй хяналтгүй зарцуулсан	1	96,339.5	-	-	1	96,339.5	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн өдрийн 5.0 мянган төгрөгөөр тооцож цалингийн зардлаас 6,339.0 мянган төгрөгийг байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	1	-	-	-	-	-
	Дүн	4	122,742.0	1	24,938.1	1	96,339.5	2	1,464.4	-	-	-	-	-	-	-	-



Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Санал дүгнэлт гаргасан	Түгвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өрчлөлтий	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	НИЙТ		1				1		

